



**ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН
ДАРГА-ЕРӨНХИЙ ЭМЧИЙН
ТУШААЛ**

2022 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 7/779

Улаанбаатар хот

**Цэргийн төв эмнэлгийн эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны
журмыг шинэчлэн батлах тухай**

Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.16, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/558 дугаар тушаал, Эрдмийн зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус эмнэлгийн эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг хавсралтаар баталсугай.

2. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг баримтлан сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх, зөвлөлийн гишүүдийн ажлын хуваарийг гаргаж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрдмийн зөвлөлийн орлогч дарга /дэд хурандаа А.Ганбат/, эрдэмтэн нарийн бичгийн дарга /дэслэгч Б.Булган/ нарт үүрэг болгосугай.

3. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилтийг тухай бүр шийдвэрлэж ажиллахыг Санхүүгийн албаны дарга-ерөнхий санхүүч /хошууч Б.Оюунгэрэл/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, хамтын ажиллагаа эрхэлсэн орлогч дарга /хошууч Л.Энхбаяр/-д даалгасугай.

ДАРГА-ЕРӨНХИЙ ЭМЧ
ХУРАНДАА  Б.ЭНХ-ОД



6101001256

Tushaal2022 A-4docXXHЖ-02-д

Цэргийн төв эмнэлгийн дарга-
ерөнхий эмчийн 2022 оны 11 дүгээр
сарын 28 өдрийн 449 дугаар
тушаалын хавсралт



ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Цэргийн төв эмнэлгийн Эрдмийн Зөвлөл нь Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль, байгууллагын дотоод дүрэмд зааснаар тус эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн төгсөлтийн дараах болон тасралтгүй сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны асуудлаар шийдвэр гаргах эрх бүхий хамтын удирдлагын зөвлөл юм.

1.2. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Эрдмийн зөвлөлийн хурал байна.

1.3. Эрдмийн Зөвлөл нь дэргэдээ “Цэргийн эмч” сэтгүүлтэй байх бөгөөд үүгээрээ дамжуулан онолын болон судалгаа шинжилгээний бүтээлүүдийг нийтэд түгээн дэлгэрүүлнэ.

Хоёр. Эрдмийн зөвлөлийн зохион байгуулалт, бүрэлдэхүүн

2.1. Эрдмийн Зөвлөлийн гишүүдийг Цэргийн төв эмнэлгийн даргын тушаалаар 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна. Зөвлөлийн гишүүдийг 80-аас доошгүй хувь нь докторын зэрэгтэй байх бөгөөд Цэргийн төв эмнэлгийн болон тус эмнэлэгт ажиллаж байсан, БХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөл, БХЭШХ, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, боловсролыг дэмжигч нийгмийн түншлэлийн зэрэг байгууллагын төлөөлөл байна.

2.2. Эрдмийн Зөвлөл нь зөвлөлийн дарга, хоёр орлогч дарга, эрдэмтэн нарийн бичгийн дарга, гишүүд гэсэн бүтэц бүрэлдэхүүнтэй байна.

2.3. Эрдмийн зөвлөлийн дарга нь Цэргийн төв эмнэлгийн Дарга-ерөнхий эмч байна.

2.4. Цэргийн төв эмнэлэг болон эрдэм шинжилгээний хүрээлэн эсвэл Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төлөөллөөс сонгогдсон хоёр орлогч даргатай байх ба шаардлагатай тохиолдолд даргын эзгүйд орон ажиллана.

2.5. Эрдэмтэн нарийн бичгийн дарга нь хурлын бэлтгэлийг хангах, Эрдмийн зөвлөлийн тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг нэгтгэх, бичиг хэргийг бүртгэн хөтлөх ажлыг хариуцна.

2.6. Эрдмийн зөвлөлд гишүүний сул орон тоо гарсан тохиолдолд Эрдмийн зөвлөлөөс нөхөн сонголт хийхээр шаардлага хангах эрдэмтдийг сонгож Дарга-ерөнхий эмчийн тушаалаар батална

2.7. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 жил тутамд ажлын үр дүнг харгалзан шинэчилнэ

2.8. Эрдмийн зөвлөл нь Цэргийн төв эмнэлгийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

Гурав. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаа

3.1. Эрдмийн зөвлөл жилд хоёроос доошгүй удаа хуралдана.

3.2. Эрдмийн зөвлөл үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллана.

3.3. Эрдмийн Зөвлөлийн хурлаас дараах асуудлаар тогтоол, шийдвэр гарна. Үүнд:

- Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журам, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн батлах,

- Цэргийн төв эмнэлгийг хөгжүүлэх ойрын болон хэтийн стратеги төлөвлөгөө, бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрт санал, зөвлөмж гаргах,

- Эмнэлгийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, стандартад санал оруулах,

- Дотоод, гадаадын эмнэлэг, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах чиглэлийг тодорхойлох, гэрээ хэлэлцээр байгуулах асуудлыг хэлэлцэн санал боловсруулах,

- Цэргийн төв эмнэлгийн Клиникийн болон хүндэт профессор цол олгуулахаар нэр дэвшүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх /Гадаадын иргэнд Цэргийн төв эмнэлгийн хүндэт профессор цол олгох асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргана/.

- Эрдэм шинжилгээний төсөл, инновацийн болон хамтарсан төсөл, Засгийн газрын захиалгат төслийн аргачлал, суурь судалгааны үр дүнд үнэлэлт, дүгнэлт гаргах,

- Эрдэм шинжилгээ, судалгааг дэмжих сангаас санхүүжүүлэх чиглэл, түүний зарцуулалтын талаар хэлэлцэж санал, зөвлөмж гаргах,

- Эмнэл зүйн төв, алба, тасаг, нэгжээс эрдмийн шилдэг бүтээлийн шагналд нэр дэвшүүлж буй бүтээлийг хэлэлцэн Даргын зөвлөлд санал хүргүүлэх.

- Цэргийн төв эмнэлгийн Клиникийн профессор цол олгохоор нэр дэвшүүлсэн хүний асуудлыг Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн зөвлөлөөс тогтоол гаргах,

- Эрдэм шинжилгээ, судалгааны шилдэг бүтээлд нэр дэвшсэн бүтээлийг хэлэлцэн тогтоол гаргах,

- "Цэргийн эмч" сэтгүүлийн нийтлэлийн бодлогыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, ерөнхий редактор, редакцийн зөвлөлийн гишүүдийг томилох санал гаргах,

Дөрөв. Эрдмийн зөвлөл, түүний гишүүдийн эрх, үүрэг

4.1. Эрдмийн зөвлөлийн эрх:

4.1.1. Цэргийн төв эмнэлгийн хөгжлийн төлөв, эрдэм шинжилгээ, технологийн шинэчлэлтэй холбоотой бодлогын баримт бичгийг хэлэлцэн санал дүгнэлт гаргах,

4.1.2. Улсын болон Батлан хамгаалах яамны төсвөөр хийгдэх төсөл хөтөлбөр, эрдэм шинжилгээний төсөлт ажлыг захиалах санал дэвшүүлэх, төслийн үр дүнг хэлэлцэн үнэлэлт дүгнэлт гаргах,

4.1.3. Эрүүл мэнд, Боловсрол, Шинжлэх ухааны тулгамдсан асуудлаар санал боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх, асуулга тавих,

4.1.4. Төрийн болон төрийн бус эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын шагналд нэр дэвшсэн анагаах ухааны эрдэм шинжилгээ, технологийн шилдэг бүтээлийг хэлэлцэж шийдвэр, санал дүгнэлт гаргах,

4.1.5. Цэргийн төв эмнэлгээс төрөл мэргэжлээр Клиникийн профессор цол олгуулахаар холбогдох журмын дагуу нэр дэвшүүлж шалгарсан нэр дэвшигчдийг хэлэлцэж шийдвэрлэх

4.2. Эрдмийн зөвлөлийн үүрэг:

4.2.1. Цэргийн төв эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийн тасралтгүй сургалт, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмнэл зүйн судалгаа, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүй, аргачлалын чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах,

4.2.2. Эмнэлгийн шинжлэх ухаан технологийн талаар баримтлах бодлоготой нийцсэн хамтын ажиллагааг сайшаан дэмжих, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх,

4.2.4. Эрдмийн зөвлөлийн даргын шийдвэрээр сургалт, эрдэм шинжилгээ судалгааны ажлын хэсгийн багт оролцон ажиллах.

4.3. Эрдмийн Зөвлөлийн гишүүдийн эрх:

4.3.1. Эрдмийн зөвлөлд асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлэх, сонгох, сонгогдох.

4.3.2. Эрдмийн зөвлөлийн хуралдаанд таслан шийдвэрлэх эрхтэй оролцох, ажлаа үнэлүүлэх, урамшуулал авах.

4.3.3. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны талаар санал бодлоо хэлэх, шүүмжлэх, хэлэлцэж буй асуудлын талаар саналын зөрөөтэй байдлаа хурлын тэмдэглэлд тэмдэглүүлэх.

4.3.4. Эрдмийн зөвлөлийн гишүүнээс татгалзах.

4.3.5. Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг биелүүлэхийг Цэргийн төв эмнэлгийн бүх шатны дарга, албан тушаалтан болон холбогдох хүмүүсээс шаардах.

4.4. Эрдмийн зөвлөлийн гишүүд нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

4.4.1. Эрдмийн Зөвлөлийн хурал болон зөвлөлөөс зохион байгуулсан бусад арга хэмжээнд идэвхтэй оролцох, шийдвэрийг биелүүлэхэд бусдад үлгэр жишээ үзүүлэх,

4.4.2. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, эрдэм шинжилгээний ажилтны залгамж халааг бэлтгэх,

4.4.3. Эрдмийн зөвлөлийн нэр хүндийг хамгаалах, гишүүний нэр төрийг өндөрт өргөх,

4.4.4. Эрдмийн Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлэх,

4.4.5. Эрдмийн зөвлөлийн гишүүн нь эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллах.

Тав. Эрдмийн зөвлөлийн хурал түүний дэг, гаргах шийдвэр

5.1. Эрдмийн зөвлөлийн хурлыг Эрдмийн зөвлөлийн дарга даргалах ба түүний эзгүйд Зөвлөлийн орлогч дарга зарлан хуралдуулж даргална.

5.2. Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбоотой баримт бичгийг ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө гишүүдэд хүргүүлсэн байна.

5.3. Эрдмийн зөвлөлийн хуралд гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хүрэлцэн ирсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.

5.4. Эрдмийн зөвлөлийн хурал нээлттэй, хаалттай болон цахим хэлбэрээр хуралдана.

5.5. Хурлын дарга хуралдааны эхэнд дэгийг танилцуулж баталсны дараа түүний дагуу хуралдааныг удирдана.

5.6. Хуралд асуулт асуух, үг хэлэх, тайлбар тавих зөвшөөрлийг хурлын дарга олгоно.

5.7. Хурлаар хэлэлцсэн асуудлыг ил ба нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Санал дүгнэлт гаргахад тооллогын комисс томилж нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Санал хураалтад оролцсон гишүүдийн 75-аас дээш хувь нь дэмжсэн тохиолдолд шийдвэрийг хүчинтэйд тооцно.

5.8. Хурлын төгсгөлд хэлэлцсэн асуудлаар Эрдмийн зөвлөлийн хурлын тогтоолын төслийг танилцуулж батлуулна. Хурлын явцад тэмдэглэл хөтлөх ба хурлын тэмдэглэл, тогтоолыг Эрдмийн зөвлөлийн дарга, Эрдэмтэн нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. Хурлын явцад дуу болон видео хэлбэрээр бичлэг хийж хурлын тэмдэглэлийг бичихэд ашиглаж болох ба хурлын тэмдэглэл, тогтоолыг архивлана.

Зургаа. Эрдмийн зөвлөлийн санхүүжилт

6.1. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаа нь дараах эх үүсвэрээс санхүүжнэ:

- Цэргийн төв эмнэлгийн төсөв
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих сан
- Судалгааны төсөлт ажил хэлэлцүүлж, үнэлгээ дүгнэлт гаргуулж буй баг, хамтлагийн цагийн урамшуулал,
- Цол, зэрэг олгож буй диплом үнэмлэхийн хураамж,
- Хандив, тусламж,
- Бусад эх үүсвэр.

6.2. Эрдмийн зөвлөлийн гишүүдэд болон шинжээчдийн баг, үнэлгээний хэсэгт ажлын хөлс (хурлын нэг цагт 10000 төгрөг байхаар тооцно).

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ